**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2022 оны 07 сарын 18 өдөр Дугаар A/373 Улаанбаатар хот

Журам, заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалтыг өргөжүүлэх журмыг нэгдүгээр, Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх зааврыг хоёрдугаар, Томуу, томуу төст өвчний тархалтын түвшинг тогтоох зааврыг гуравдугаар, Томуу, томуу төст өвчний тархалтын түвшинд тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээний чиглэлийг дөрөвдүгээр, лабораторид суурилсан тандалтын зааврыг тавдугаар, Томуугийн харуулдан тандалтын нэгж, вирус судлалын лабораторийн жагсаалтыг зургаадугаар, Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх зааврыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын мэдээ, мэдээлэл солилцоо, бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар /Д.Нарантуяа/, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга нарт даалгасугай.

3. Вирус судлалын лавлагаа, бүсийн болон салбар лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж, оношлуурын зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт даалгасугай.

4. Интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн системийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, лабораторийн шинжилгээ, хариу арга хэмжээний мэдээлэл цуглуулахад ашиглаж буй цахим програмтай үе шаттай нэгтгэх ажлыг зохион байгуулж, цахимын аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358, 2020 оны А/482, А/583, 2021 оны А/463 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
07 дугаар сарын 18-ны өдрийн А/373 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

# ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН ТОГТОЛЦООНД СУУРИЛАН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАНДАЛТЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Томуугийн харуулдан тандалтын тогтолцооны тогтвортой байдлыг хангах, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалттай уялдуулан өргөжүүлснээр томуу, томуу төст өвчлөлийн зүй тогтол, хандлага, тархалт, вирусийн хувилбарыг тогтоож, бэлэн байдал, хариу арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын “Ногоон” түвшинд энэхүү журам, зааврыг, “Шар, Улбар шар, Улаан” түвшинд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, хариу арга хэмжээний батлагдсан бусад заавар, журмыг мөрдөнө.

1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшингээс үл хамаарч, томуугийн харуулдан тандалтыг тасралтгүй хийнэ.

1.4. Шалтгаан тодорхойгүй амьсгалын замын халдварын кластер өвчлөл, өвөрмөц тохиолдлыг томуугийн харуулдан тандалтын тогтолцоогоор тандана.

## Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. “Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо” гэж сонгогдсон эрүүл мэндийн байгууллага болон хилийн нэвтрэх цэгт түшиглэсэн ТТӨ, амьсгалын замын цочмог хүнд халдвар (АЗЦХХ)-ын тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн цогц тандалтыг;

2.2. “Амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын нэгж” гэж ТТӨ-ий тохиолдлын тодорхойлолтын дагуу тархвар судлалын болон вирус судлалын тандалтыг хийж байгаа сонгогдсон эрүүл мэндийн байгууллагыг;

2.3. “Эмнэлэгт суурилсан томуугийн харуулдан тандалтын нэгж” гэж АЗЦХХ-ын тохиолдлын тодорхойлолтын дагуу тархвар судлал болон вирус судлалын тандалтыг хийж байгаа сонгогдсон эрүүл мэндийн байгууллагыг;

2.4. “Тандалтын нэмэлт нэгж” гэж амьсгалын замын вирус илрүүлэх сорьц цуглуулах, шаардлагатай үед шинжилгээ хийх хилийн нэвтрэх цэгт байгуулсан лаборатори эсхүл тухайн орон нутгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг;

2.5. “Томуугийн улирал” гэж тухайн жилийн тархвар судлалын 40 дүгээр долоо хоногоос дараа жилийн 23 дугаар долоо хоног хүртэлх хугацааг;

2.6. “Томуугийн жил” гэж тухайн жилийн тархвар судлалын 40 дүгээр долоо хоногоос дараа жилийн 39 дүгээр долоо хоног хүртэлх хугацааг;

2.7. “Вирус судлалын лавлагаа лаборатори” гэж томуу, ТТӨ, амьсгалын замын бусад халдварын үүсгэгчийг бх-ПГУ шинжилгээгээр илрүүлэх, томуугийн вирусийн хэвшинж, дэд хэвшинжийг тогтоох, вирусийн геномын бүрэн дараалыг тодорхойлох шинжилгээгээр SARS-CoV-2 вирусийн хувилбар илрүүлэх чадавхитай Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийн Вирус судлалын лабораторийг;

2.8. "Вирус судлалын бүсийн лаборатори" гэж томуу, ТТӨ, амьсгалын замын бусад халдварын үүсгэгчийг бх-ПГУ шинжилгээгээр илрүүлэх, томуугийн вирусийн хэвшинж, дэд хэвшинжийг тогтоох молекул биологийн лабораторийг;

2.9. "Вирус судлалын салбар лаборатори" гэж бх-ПГУ шинжилгээгээр томуугийн вирусийн хэвшинж, SARS-CoV-2 вирус илрүүлэх вирус судлалын бүсийн лабораториос бусад аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад байрлах молекул биологийн лабораторийг;

2.10. "ТТӨ-ий тархалтын үе шат" гэж ДЭМБ-аас гаргасан "Улирлын томуу, томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээ"-ний аргачлалаар ТТӨ-ий халдварлалтын зэрэг, үр нөлөөг матрицаар үнэлж, тухайн жилийн босго үзүүлэлтэд харьцуулан тогтоохыг хэлнэ.

## Гурав. Тохиолдлын тодорхойлолт

3.1. Томуу, томуу төст өвчин гэдэг нь сүүлийн 10 хоногт 38$^0$C ба түүнээс дээш хэм хүрч халуурах, ханиалгах, хоолой өвдөх шинж илрэх амьсгалын замын цочмог халдвар (Өвчний олон улсын ангилал-10: кодJ00-J22+U.07.1, U.07.2)-ыг;

3.2. Амьсгалын замын цочмог хүнд халдвар гэдэг нь сүүлийн 10 хоногт 38$^0$C ба түүнээс дээш хэм хүрч халуурах, ханиалгах шинж илрэх эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай амьсгалын замын цочмог халдвар (Өвчний олон улсын ангилал-10: код-J00-J22+U.07.1,U.07.2)-ыг;

3.3. "Кластер өвчлөл" гэж асрамжийн газар, хорих анги, саатуулах байр, амралт, сувиллын газар зэрэг хязгаарлагдмал орчинд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд эмнэлзүйн ижил шинж тэмдэг илрэх.

## Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

4.1.1. ТТӨ, АЗЦХХ-ыг тандах, сэргийлэх, хянах, эрт илрүүлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжилтийг хянана.

4.1.2. Дэлхий дахинд анхаарал татсан томуугийн вирусийн хэвшинж болон дэд хэвшинж, SARS-CoV-2 вирусийн хувилбар шинээр мэдээлэгдсэн тохиолдолд гадаад улс орноос ирж байгаа иргэдэд хилийн нэвтрэх цэгт тандалт, хариу арга хэмжээг зохион байгуулах шийдвэр гаргана.

4.1.3. ТТӨ, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын онцгой комисс, холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангаж, шаардлагатай үед холбогдох шийдвэр гаргуулна.

4.1.4. Улирлын томуу, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

4.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв:

4.2.1. ТТӨ, АЗЦХХ-ыг тандах, сэргийлэх, хянах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах чиглэлээр үйл ажиллагааны журам, зааврыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж ажиллана.

4.2.2. ТТӨ-ий нөхцөл байдал, ДЭМБ-аас гаргасан удирдамжтай уялдуулан тандалт, хариу арга хэмжээний бодлогын баримт бичгийг тухай бүрт шинэчлэнэ.

4.2.3. ТТӨ-ий тархалтын үе шатанд тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийнэ.

4.2.4. Томуугийн харуулдан тандалтын долоо хоног бүрийн мэдээнд дүн шинжилгээ хийж, тархалтын үе шатыг тогтоон хариу арга хэмжээний саналыг тусгасан эргэн мэдээлэл бэлтгэж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

4.2.5. ДЭМБ-ын "Улирлын томуу, томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээ"-ний аргачлалын дагуу улсын хэмжээний өвчлөлийн босго үзүүлэлтийг жил бүрийн 9 дүгээр сард шинэчилж гаргана.

4.2.6. "Томуугийн Үндэсний зөвлөлгөөн"-ийг жил бүр зохион байгуулж, тандалт, хариу арга хэмжээний зөвлөмж гарган хэрэгжүүлнэ.

4.2.7. Жил бүр томуугийн цар тахлын бэлэн байдлыг хангах зорилгоор олон салбарыг оролцуулсан сургалт, ширээний дасгал сургуулилт зохион байгуулна.

4.2.8. Улирлын томуу, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины тооцоог жил бүр гарган, захиалах, вакцины түгээлт, дархлаажуулалтын явцад хяналт хийж тайлагнана.

4.2.9. Вирусийн эсрэг эм, лабораторийн хэрэгсэл, урвалж оношлуур, сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх, яаралтай тусламжийн эм, халдваргүйжүүлэлтийн бодисын тооцоог жил бүр гарган, ЭМЯ болон холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.2.10. Бүсийн болон салбар вирус судлалын лаборатори, харуулдан тандалтын болон нэмэлт нэгжүүдэд дэмжлэгт хяналт хийн, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангана.

4.2.11. Томуугийн харуулдан тандалтын нэгжийн үйл ажиллагааг жил бүр цахим байдлаар үнэлж, тайланг ЭМЯ болон холбогдох байгууллагуудад танилцуулж, зөвлөмж гарган хэрэгжүүлнэ.

4.2.12. Эрүүл мэндийн ажилтнуудад томуу, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, эмнэлзүй, халдварын сэргийлэлт, хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлээр сургалт зохион байгуулж, чадавхжуулна.

4.2.13. Томуугийн цар тахлын бэлэн байдлын үнэлгээг эрүүл мэндийн байгууллагуудад 3 жил тутамд хийж, тайланг ЭМЯ болон холбогдох газруудад танилцуулж, зөвлөмж хүргүүлнэ.

4.2.14. ТТӨ, АЗЦХХ-ын тархвар зүй, эмнэлзүйн нөхцөл байдал өөрчлөгдөх, лабораторийн шинжилгээнд томуу, SARS-CoV-2 вирусийн шинэ хувилбар илрэх, шалтгаан тодорхойгүй амьсгалын замын халдварын кластер өвчлөл бүртгэгдсэн үед эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.2.15. ТТӨ-ий тархалтын үе шатанд тохируулан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хязгаарлах, сурагчдын амралтыг сунгах, олон нийтийн арга хэмжээг нийтээр болон хэсэгчлэн хязгаарлах саналыг ЭМЯ, холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

4.2.16. ТТӨ-ий тархварзүй, вирус судлал, эмнэлзүйн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийж, үр дүнг хэлэлцүүлэн, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангана.

4.2.17. Үндэсний түвшинд вирус судлалын лабораториудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, тасралтгүй байдлыг хангах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан ЭМЯ болон холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.2.18. Бүсийн болон салбар лабораториудын шинжилгээний гадаад чанар, био-аюулгүй ажиллагааг хянана.

4.2.19. Вирус судлалын лавлагаа лабораторид шаардлагатай урвалж, оношлуурыг захиалж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.

4.2.20. Томуугийн болон SARS-CoV-2 вирусийн зарим омгуудыг ДЭМБ-ын лавлагаа төвүүдэд илгээж, баталгаажуулна.

4.2.21. Томуугийн вирусийн хэвшинж, дэд хэвшинж, эмийн бодист тэсвэржилтийг тодорхойлж, мэдээллээр хангана.

4.2.22. SARS-CoV-2 вирусийн хувилбарын тандалт болон томуугийн вирусийн геномын бүрэн дараалал тогтоох шинжилгээ хийж, үр дүнг дэлхийн генийн мэдээллийн сан GISAID-д байршуулна.

4.2.23. Томуугийн тандалтын мэдээллийг долоо хоног бүрийн Пүрэв гарагт ДЭМБ-ын FluNet, FluID сүлжээ болон үндэсний www.flu.mn вэб хуудсанд тавьж, мэдээллийг шуурхай солилцон ажиллана.

4.2.24. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүн амыг үнэн зөв, бодит мэдээллээр шуурхай хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3. Эрүүл мэндийн хөгжлийн төв:

4.3.1. ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үед нэмэлтээр дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтан, резидент эмч, анагаахын чиглэлээр суралцаж буй төгсөх ангийн оюутан, сайн дурын ажилтны судалгааг гаргаж, баримжаа олгох сургалтыг зохион байгуулна.

4.4. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв:

4.4.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд ТТӨ-ий тархварзүйн болон вирус судлалын тандалтыг хийх, дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр шинэчлэнэ.

4.4.2. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд ТТӨ-ий тархалтын үе шатыг үнэлж, ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгж (ТҮН)-д хавсралт 2-т заасны дагуу мэдээлнэ.

4.4.3. Долоо хоног бүр ТТӨ, АЗЦХХ, вирус судлалын тандалтын мэдээнд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

4.4.4. Өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд “Улирлын томуу болон томуугийн цар тахлын хүндрэлийг үнэлэх” аргачлалын дагуу жил бүрийн 8 дугаар сард босго үзүүлэлтийг шинэчилж, ХӨСҮТ-ийн ТҮН-д хүргүүлж, баталгаажуулна.

4.4.5. Эрсдэлт бүлгийн хүн амын судалгаанд үндэслэн улирлын томуугийн вакцины хэрэгцээг төлөвлөж, ХӨСҮТ-ийн ТҮН-д тухайн оны 8 дугаар сард багтаан хүргүүлж, дархлаажуулалтыг зохион байгуулна.

4.4.6. Томуугийн улиралд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, вирусийн эсрэг эм, түргэвчилсэн тестийн нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгана.

4.4.7. Вирус судлалын лабораторид шаардлагатай урвалж, оношлуур, лабораторийн хэрэгсэл, стандарт вирус тээвэрлэх орчин, сорьц тээвэрлэх тээврийн зардлын тооцоог гаргаж, жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлүүлнэ.

4.4.8. ТТӨ-ий дэгдэлтийн үед нэмэлтээр дайчлан ажиллуулах хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, сайн дурын идэвхтнүүдийг дайчлан ажиллуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.4.9. Харуулдан тандалтын болон нэмэлт нэгжүүдэд дэмжлэгт хяналт хийн, сургалт зохион байгуулж, мэргэжил аргазүйн удирдлагаар хангана.

4.4.10. Амьсгалын замын халдварын кластер өвчлөл, эмнэлзүйн өвөрмөц тохиолдол бүртгэгдвэл ХӨСҮТ-ийн ТҮН-д 24 цагийн дотор мэдээлж, эрсдэлийн үнэлгээ хийж, голомтод шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулна.

4.4.11. ТТӨ-ий тархалтын үе шатыг харгалзан сургууль, цэцэрлэгийг хаах, сурагчдын амралтыг сунгах, олон нийтийн арга хэмжээг нийтээр болон хэсэгчлэн хязгаарлах саналыг аймаг, нийслэлийн засаг захиргааны нэгжид хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.4.12. Орон нутгийн засаг захиргаа болон холбогдох байгууллагуудтай хамтран 5 хүртэлх насны хүүхдийг чийрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.4.13. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүн амыг үнэн, бодит мэдээллээр шуурхай хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.5. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймаг, нийслэлийн Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага:

4.5.1. Нутаг дэвсгэрийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүндрэл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

4.5.2. ТТӨ-ий тархварзүйн болон вирус судлалын тандалт хийх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг гарган, бэлэн байдлыг хангаж ажиллана.

4.5.3. Жил бүр ор дэлгэх төлөвлөгөөнд тодотгол хийж, төлөвлөгөөний дагуу орны зохицуулалтыг хийнэ.

4.5.4. Эмнэлэгт суурилсан тандалтын мэдээг бүх тасгаас цуглуулж, харъяа ЭМГ, ХӨСҮТ-ийн ТҮН-д 2 дугаар хавсралтын дагуу мэдээлнэ.

4.5.5. Томуугийн харуулдан тандалтын нэгжүүд ТТӨ-ий тархалтын үе шатаас хамаарч 7 хоног бүр тохиолдлын тодорхойлолтын дагуу 2-10 сорьц цуглуулж, харъяа аймаг, дүүргийн вирус судлалын лабораторид хүргүүлнэ.

4.5.6. "Улирал хоорондын үе"-д ТТӨ, АЗЦХХ-ын тохиолдол бүрээс сорьц авч шинжилнэ.

4.5.7. Томуугийн улиралд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, вирусийн эсрэг эм, түргэвчилсэн тестийн нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусган шийдвэрлүүлнэ.

4.5.8. Вирус судлалын лабораторид шаардлагатай урвалж, оношлуур, лабораторийн хэрэгсэл, стандарт вирус тээвэрлэх орчин, сорьц тээвэрлэх тээврийн зардлын тооцоог гаргаж, төсөвт тусгаж, нэмэлт санхүүжилтийг засаг захиргаа, олон улсын байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

4.5.9. Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, хүчилтөрөгчийн хангамжийн тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

4.5.10. Томуугийн улирал эхлэх үед томуу, SARS-CoV-2 вирусийн түргэвчилсэн тестийг хэрэглэж, хэрэв эерэг тохиолдолд бх-ПГУ шинжилгээнд баталгаажуулах сорьц авч, шинжилгээний хариуг хүлээлгүйгээр эмчилгээг эхэлнэ.

4.5.11. Халдварын сэргийлэлт хяналтын багийн тандалт, хяналтын үйл ажиллагааг сайжруулах, хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах, гарын эрүүл ахуйг сахих, халдваргүйгүйжүүлэх бодисыг зөв хэрэглэх, цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг тогтмол сургана.

4.5.12. Халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулж, зөвлөмж өгнө.

4.6. Өрх, сумын Эрүүл мэндийн төв:

4.6.1. Нутаг дэвсгэрийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүндрэл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

4.6.2. Жил бүр ТТӨ-ий тархварзүйн болон вирус судлалын тандалтыг хийх, дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг шинэчилнэ.

4.6.3. ТТӨ-ий мэдээг цуглуулж, харъяа дүүргийн ЭМТ, аймаг, нийслэлийн ЭМГ-т 7 хоног тутам, томуугийн харуулдан тандалтын нэгжүүд ХӨСҮТ-ийн ТҮН-д өдөр бүр 2 дугаар хавсралтын дагуу мэдээлнэ.

4.6.4. Томуугийн харуулдан тандалтын нэгжүүд ТТӨ-ий тархалтын үе шатанд тохируулан 7 хоног бүр тохиолдлын тодорхойлолтын дагуу өрхийн эрүүл мэндийн төв 2-10 сорьц авч харъяа аймаг, дүүргийн вирус судлалын лабораторид хүргүүлнэ.

4.6.5. "Улирал хоорондын үе"-д ТТӨ, АЗЦХХ-ын тохиолдол бүгдээс сорьц авч шинжилнэ.

4.6.6. ТТӨ-ий дэгдэлтийн үед нэмэлт цагаар ажиллах эрүүл мэндийн ажилтны хуваарийг төвийн даргаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллана.

4.6.7. Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, вирусийн эсрэг эм, вирус тээвэрлэх стандарт орчин, вирус судлалын лабораторид хүргүүлэх тээврийн зардлын тооцож, жил бүрийн төсөвт тусгана. Шаардлагатай бол харъяа засаг захиргаа, бусад холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж санхүүжилтыг шийдвэрлүүлнэ.

4.6.8. Жил бүр эрсдэлт бүлгийн хүн ам, гахай, шувуу тэжээдэг айл өрх, аж ахуй нэгжийн судалгааг шинэчлэн, идэвхтэй тандалт хийнэ.

4.6.9. Томуугийн улирал эхлэх үед томуу, SARS-CoV-2 вирусийн түргэвчилсэн тестийг хэрэглэж, хэрэв эерэг тохиолдолд бх-ПГУ-ын шинжилгээнд баталгаажуулах сорьц авч, шинжилгээний хариуг хүлээлгүйгээр эмчилгээг эхэлнэ.

4.6.10. Үйлчлэх хүрээний хүн амын дунд шалтгаан тодорхойгүй амьсгалын замын халдварын кластер өвчлөл, өвөрмөц тохиолдол бүртгэгдвэл аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМТ-д 24 цагийн дотор мэдээлж, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлнэ.

4.6.11. Халдварын сэргийлэлт хяналтын багийн тандалт, хяналтын үйл ажиллагааг сайжруулах, хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах,

гарын эрүүл ахуйг сахих, халдваргүйжүүлэх бодисыг зөв хэрэглэх, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг тогтмол сургана.

4.6.12. Орон нутгийн засаг захиргаа болон холбогдох байгууллагуудтай хамтран 5 хүртэлх насны хүүхдийг чийрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.6.13. Халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулж, зөвлөмж өгнө.

4.7. Бүсийн болон салбар лаборатори:

4.7.1. Бүсийн болон салбар лаборатори нь дараах чиг үүргийн хүрээнд ажиллана (Зураг 1).

*Зураг 1. Вирус судлалын лабораторийн чиг үүрэг*



4.7.3. Орчилд байгаа вирус, тухайн цаг үеийн нөхцөл байдал, хамаарч лаборатори нь А болон В алгоритмын дагуу шинжилгээг хийж гүйцэтгэнэ.

**А-АЛГОРИТМ. ТОМУУГИЙН ВИРУС ЭХЭЛЖ ШИНЖЛЭХ**




**В-АЛГОРИТМ. SARS-COV-2 ВИРУС ЭХЭЛЖ ШИНЖЛЭХ**




4.7.4. Тандалтын шинжилгээний хариуг шинжилгээ хийсэн эмч, лаборант 24 цагийн дотор интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн систем (ИСТМС (http://fis.flu.mn))-д оруулна.

4.7.5. Вирус судлалын бүсийн болон салбар лаборатори томуу, SARS-CoV-2 вирус илэрсэн анхны сорьцыг 24-48 цагийн дотор лавлагаа лабораторид хүргүүлж, баталгаажуулсны дараа үр дүнг ИСТМС (http://fis.flu.mn)-д оруулна.

4.7.6. Салбар лаборатори тандалтын сорьцод томуугийн вирусийн А (H1, H3 дэд хэвшинж) ба В хэвшинж, SARS-CoV-2 вирусийн генийг бх-ПГУ-ын шинжилгээгээр илрүүлнэ. Томуугийн вирусийн H1, H3 дэд хэвшинж илрээгүй тохиолдолд сорьцыг лавлагаа лабораторид 24-48 цагийн дотор хүргүүлнэ.

4.7.7. Салбар лаборатори нь SARS-CoV-2 болон томуугийн вирус илрээгүй сорьцноос санамсаргүй түүврийн аргаар 2-5 хүртэлх сорьц сонгож Пүрэв гараг бүр 16 цагаас өмнө бүсийн лабораторид хүргүүлж томуу тест өвчний үүсгэгчийг тандана.

4.7.8. Бүсийн болон салбар лаборатори нь SARS-CoV-2, томуугийн вирус илэрсэн сорьцыг хавсралт 5-д заасны дагуу хадгалж, хувилбарын тандалтын шаардлага хангасан сорьцыг лавлагаа лабораторид хүргүүлнэ.

4.7.9. Бүсийн болон салбар лаборатори сорьцыг -70°C хэмийн гүн хөлдөөгчинд цэгцтэй хадгалж, бүртгэлжүүлнэ. Лавлагаа лабораторид сорьцыг дагалдах хуудас (Маягт 7)-ын хамт хөлдүү байдалтай илгээнэ.

4.7.10. Тухайн долоо хоногт шинжилсэн сорьцын мэдээллийг Ням гарагаар тасалбар болгон хавсралт 2-ын Маягт 6-д заасны дагуу "Microsoft Excel" программд шивж, virologylabmng@nccd.gov.mn хаягаар лавлагаа лабораторид илгээнэ.

4.7.11. Бүсийн болон салбар лаборатори нь био аюулгүй ажиллагаа болон шинжилгээний ажилбарын урсгалыг ХӨСҮТ-ийн зөвлөмж, зааврын дагуу зохион байгуулна.

4.8. Хилийн нэвтрэх цэг:

4.8.1. Хилийн нэвтрэх цэгийн эрх бүхий байгууллага томуугийн шинэ вирус, Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор "Бэлэн байдлын төлөвлөгөө"-нд жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр тодотгол хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллана.

4.8.2. Хилийн нэвтрэх цэгт томуу, ТТӨ, Коронавируст халдварын үүсгэгчийг илрүүлэх вирус судлалын лабораторийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

4.9. Гаалийн хорио цээрийн байгууллага:

4.9.1. Хилийн боомт, гүний хяналтын бүсэд томуугийн шинэ вирус, Коронавируст халдвар болон Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ээр зохицуулагддаг бусад өвчний сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, эмийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангаж ажиллана.

4.9.2. Агаарын хилийн боомт дээр Иргэний нисэхийн ерөнхий газрын дэргэдэх APIS (Advance passenger information system) цахим програмын тусламжтайгаар зорчигчийн мэдээллийг урьдчилан авч, эрүүл мэндийн хяналт хийж, хариу арга хэмжээг төлөвлөнө.

4.9.3. Онгоцны нисэх багийн даргаас зорчигчийн эрүүл мэндийн ерөнхий мэдүүлэг, галт тэрэгний дарга, үйлчлэгч, автобус, автомашины жолоочоос зорчигчийн эрүүл мэндийн мэдээлэл, зорчигчийн тоо, суудлын дугаар бүхий нэрсийн жагсаалтыг авч, хяналт тандалт хийнэ.

4.9.4. Хилээр нэвтэрч буй зорчигч, жолоочийн биеийн халууныг зайнаас хэмжин, "зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг" хуудсыг бөглүүлж, халдварын сэжигтэй

тохиолдол илэрвэл түр тусгаарлан, холбогдох байгууллагад шуурхай мэдээлж, харьяа эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

4.9.5. Удирдах дээд байгууллага, мэргэжлийн байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу хилийн нэвтрэх цэгт зорчигчдоос түргэвчилсэн болон бх-ПГУ шинжилгээ авах ажлыг зохион байгуулна.

4.9.6. Хилээр нэвтрүүлж буй зорчигч, жолооч нараас шаардлагатай тохиолдолд олон улсын хөл хориот өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын гэрчилгээг шаардана.

4.9.7. Улсын хилээр нэвтрүүлж буй тээврийн хэрэгсэл, ачаа тээш, чингэлэг, карго, шуудангийн илгээмж, шарилд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, халдварт өвчний сэжигтэй тохиолдлын явсан газар, талбай, түр тусгаарлах байр, ачаа тээшид халдваргүйжүүлэлт хийхэд мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналт тавина.

4.9.8. Халдварын сэжигтэй зорчигч тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл, шавж, мэрэгчээр бохирдсон ачаа, чингэлгийг "эрүүл ахуйн тусгаарлалтын бүс"-д байршуулж, дэглэмийн мөрдөлт болон халдваргүйжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавина.

4.9.9. Зорчигч, хилийн хяналтын болон бусад байгууллагыг халдвараас сэргийлэх зөвлөмжөөр хангаж ажиллана.

4.9.10. Хил залгаа улсын хорио цээрийн хяналтын байгууллагатай томуугийн болон Коронавируст халдвар, бусад нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын мэдээг солилцож, хамтарсан арга хэмжээг төлөвлөж ажиллана.

4.9.11. Улсын хилийн боомт, гүний хяналтын бүсийн хог хаягдлын зайлуулалт, устгал, хүнсний болон усны аюулгүй байдалд хяналт тавьж ажиллана.

4.9.12. Эрүүл мэндийн мэдүүлэг хуудсыг цахимжуулж, зорчигчийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, холбогдох байгууллагыг мэдээллээр хангаж ажиллана.

4.9.13. Улсын хилийн боомт, гүний хяналтын бүсэд илэрсэн халдварт өвчний сэжигтэй тохиолдолд тандалт хийж, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад шуурхай шилжүүлнэ.

4.9.14. Улсын хилийн боомтын хилийн хяналтын байгууллагын ажилтны дунд бүртгэгдсэн халдварын сэжигтэй тохиолдолд тандалт хийж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
07 дугаар сарын 18-ны өдрийн А/ 493 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

# ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН, АМЬСГАЛЫН ЗАМЫН ЦОЧМОГ ХҮНД ХАЛДВАРЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ЗААВАР

Нэг. Томуу, ТТӨ, АЗЦХХ-ын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх:

1.1. Томуугийн харуулдан тандалтын нэгж нь тохиолдлын тодорхойлолтын дагуу (Өвчний олон улсын ангилал-10: кодJ00-J22+U.07.1, U.07.2) томуу, ТТӨ, АЗЦХХ-ыг бүртгэж, ИСТМС (http://fis.flu.mn)-д оруулна.

1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын мэдээг энэхүү тушаалын 7 дугаар хавсралтын дагуу бүртгэж, мэдээлнэ.

1.3. Бусийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг нь АЗЦХХ-ын мэдээг бүх тасгуудаас авч мэдээлнэ.

1.4. Аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв нь ТТӨ-ий мэдээг бүх өрх, сумын ЭМТ-өөс авч мэдээлнэ.

1.5. ХӨСҮТ-ийн ТҮН нь тандалтын нэгжээс ирүүлсэн мэдээнд дүн шинжилгээ хийж, "Томуу, томуу төст өвчний эргэн мэдээлэл"-ийг долоо хоног бүрийн Лхагва гарагийн 15 цагаас өмнө ЭМЯ, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, бусад холбогдох газруудад цахимаар илгээнэ.

1.6. ХӨСҮТ-ийн ТҮН нь ЭХЭМҮТ-тэй хамтран томуугийн улиралд долоо хоног бүрийн Лхагва гарагийн 14 цагт "ТТӨ-ий нөхцөл байдал, хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний талаар эмч, мэргэжилтнүүдэд цахим хурал зохион байгуулна.

1.7. Тандалтын мэдээний чанарт байгууллагын удирдлага хяналт тавьж, үүссэн асуудлыг (интернет, комьютер, байнгын хариуцах мэргэжилтэн) шуурхай шийдвэрлэнэ.

1.8. Томуугийн харуулдан тандалтын нэгжийн тархвар судлагч эсхүл дүн бүртгэгч нь ТТӨ, АЗЦХХ-ын мэдээг нэгтгэн, удирдах албан тушаалтнаар хянуулсны дараа мэдээлнэ (хүснэгт 1).

Хүснэгт 1. ТТӨ, АЗЦХХ-ын мэдээ өгөх хүснэгт

| № | Мэдээний төрөл | | Маягтын дугаар | Харуулдан тандалтын нэгж | | | Хэрхэн мэдээлэх |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Өрх, сумын ЭМТ | БОЭТ, НЭ | Аймгийн ЭМГ, дүүргийн ЭМТ | |
| 1 | Амбулаторид суурилсан тандалтын мэдээ | | №1 | Өдөр бүрийн 12 цагаас өмнө | Өдөр бүр, 12 цагаас өмнө | Мягмар гараг бүр, 12 цагаас өмнө | ИСТМС (http://fis.flu.mn) |
| 2 | Эмнэлэгт суурилсан тандалтын мэдээ | | №2 | - | Мягмар гараг бүр, 12 цагаас өмнө | - | ИСТМС (http://fis.flu.mn) |
| 3 | ТТӨ-ий тархалтын үе шатаас хамаарч | Алаг цоог дэгдэлтийн үед | №3 | | Мягмар гараг бүр, 12 цагаас өмнө | | ИСТМС (http://flu.mn/medee) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээлэл цуглуулах мэдээ | Улсын хэмжээний дэгдэлтийн үед | | | Өдөр бүр, 12 цагаас өмнө | | ИСТМС (http://flu.mn/medee) |
| 4 | ТТӨ-ий "Тахалт тархалт"-ын үед цуглуулах мэдээ | | №4 | | Өдөр бүр, 12 цагаас өмнө | | ИСТМС (http://flu.mn/medee) |
| 5 | АЗЦХХ-ын шалтгаант нас баралтын мэдээ | | №5 | - | 48 цагийн дотор | - | nicmongolia@nccd.gov.mn |
| 6 | Бусийн болон салбар лабораторийн шинжилгээ хийсэн сорьцын мэдээлэл | | №6 | | Даваа гараг бүр, 12 цагаас өмнө | | virologylabmng@nccd.gov.mn |

## Хоёр. ТТӨ, АЗЦХХ-ын тандалтын мэдээ цуглуулах, мэдээлэх:

### Маягт 1. Амбулаторид суурилсан тандалтын мэдээ

| Үзүүлэлт | Насны бүлэг | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 0-11 сар | 1 нас | 2-4 нас | 5-9 нас | 10-14 нас | 15-29 нас | 30-49 нас | 50-64 нас | 65+ нас |
| Амбулаторийн нийт үзлэгийн тоо | | | | | | | | | |
| Үүнээс: ТТӨ-ий нийт тохиолдлын тоо | | | | | | | | | |
| Хаалттай болон хязгаарлагдмал орчинд бүртгэгдсэн кластер өвчлөл | | | | | | | | | |
| Амбулаторийн нийт үзлэгт ТТӨ-ий эзлэх хувь | | | | | | | | | |
| Түргэн тусламжийн дуудлагын тоо | | | | | | | | | |
| Үүнээс: ТТӨ-ий шалтгаантай дуудлагын тоо | | | | | | | | | |

### Маягт 2. Эмнэлэгт суурилсан тандалтын мэдээ

| Үзүүлэлт | Насны бүлэг | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 0-11 сар | 1 нас | 2-4 нас | 5-9 нас | 10-14 нас | 15-29 нас | 30-49 нас | 50-64 нас | 65+ нас |
| Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт өвчтөн | | | | | | | | | |
| Эдгэрч гарсан, шилжсэн | | | | | | | | | |
| Нас барсан | | | | | | | | | |
| Шинээр хэвтсэн | | | | | | | | | |
| Энэ 7 хоногийн эцэст байгаа | | | | | | | | | |
| Үүнээс: Уушгины үрэвсэл (АЗЦХХ)-аар хүндэрсэн | | | | | | | | | |
| Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт өвчтөн | | | | | | | | | |
| Эдгэрч гарсан, шилжсэн | | | | | | | | | |
| Нас барсан | | | | | | | | | |
| Шинээр хэвтсэн | | | | | | | | | |
| Энэ 7 хоногийн эцэст байгаа | | | | | | | | | |

**Маягт 3. ТТӨ-ий тархалтын үе шатаас хамаарч мэдээлэл цуглуулах**
Он/сар/өдөр:______/_____/______ Долоо хоног:________

Нэг. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн мэдээ

| Үзүүлэлт | Нийт | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | 0-15 насны хүүхэд | Насанд хүрэгчид | Жирэмсэн |
| Эмнэлэгт эмчлүүлж байгаа хүний тоо | | | | |
| Үүнээс: АЗЦХХ-аар хэвтэн эмчлүүлж байгаа хүний тоо | | | | |
| Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо | | | | |
| Үүнээс: АЗЦХХ-тай хэвтэн эмчлүүлж байгаа хүний тоо | | | | |

Хоёр. Орны зохицуулалт

| Үзүүлэлт | Нийт | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | 0-15 насны хүүхэд | Насанд хүрэгсэд | Эрчимт эмчилгээ |
| Бусад тасгаас нэмэлтээр зохицуулсан орны тоо | | | | |
| Нэмэлтээр дэлгэсэн орны тоо | | | | |

Гурав. Яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлэгчдийн мэдээ

| Үзүүлэлт | Нийт | Эмнэлэгт хэвтсэн | Гэрт буцсан |
|---|---|---|---|
| Яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлсэн хүний тоо | | | |
| ТТӨ, АЗЦХХ-тай хүний тоо | | | |

**Маягт 4. ТТӨ-ий "Тахалт тархалт"-ын үед цуглуулах мэдээ**
Он/сар/өдөр:______/_____/______

Нэг. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсэд

| Үзүүлэлт | Нийт | Жирэмсэн | Насны ангилал | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 хүртэл | 1-4 | 5-19 | 20-64 | 65+ |
| Одоо байгаа өвчтөний тоо<br>Үүнээс: АЗЦХХ-тай хүний тоо | | | | | | | |
| Шинээр эмнэлэгт хэвтсэн хүний тоо<br>Үүнээс: АЗЦХХ-тай хүний тоо | | | | | | | |
| Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо<br>Үүнээс: АЗЦХХ-тай хүний тоо | | | | | | | |
| Яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлсэн хүний тоо<br>Үүнээс: ТТӨ, АЗЦХХ-тай хүний тоо | | | | | | | |

Хоёр. Орны зохицуулалт

| Үзүүлэлт | Нийт | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | 0-15 насны хүүхэд | Насанд хүрэгсэд | Эрчимт эмчилгээ |
| Бусад тасгаас нэмэлтээр зохицуулсан орны тоо | | | | |
| Нэмэлтээр дэлгэсэн орны тоо | | | | |

**Маягт 5. АЗЦХХ-ын шалтгаант нас баралтын мэдээ**

| | |
|---|---|
| Мэдээлсэн огноо | ____/____/____ |
| Эмнэлгийн нэр | ____________ |
| Мэдээлсэн хүний нэр, албан тушаал | ____________ |
| Өвчтөний овог, нэр | ____________ |
| Төрсөн огноо | ____/____/____ |
| Нас | ____________ |
| Хүйс | ____________ |
| Өвчин эхэлсэн огноо | ____/____/____ |
| Эмнэлэгт хэвтсэн огноо | ____/____/____ |
| Нас барсан огноо | ____/____/____ |
| Үндсэн онош (ICD-10) | ____________ |
| Хавсарсан онош | ____________ |
| Архаг суурь өвчинтэй эсэх | □ Тийм □Үгүй |
| Тийм бол онош | ____________ |
| Вирусийн эсрэг эмчилгээ хийгдсэн эсэх | □ Тийм □Үгүй |
| Тийм бол хугацаа (хоног, цаг) | ____________ |
| Вирус судлалын лабораторид сорьц өгсөн эсэх | □ Тийм □Үгүй |
| Тийм бол огноо | ____/____/____ |
| Сорьцын төрөл | ____________ |
| Шинжилгээний хариу | ____________ |
| Задлан хийсэн эсэх | □ Тийм □Үгүй |
| Тийм бол огноо | ____/____/____ |
| Онош | ____________ |

**Маягт 6. Лабораторийн долоо хоног тутмын мэдээ**

| Сорьцын дугаар | Сорьцын төрөл | ПГУ-ын шинжилгээний дүн | СТ утга | Шинжлүүлэгчийн овог нэр | Нас | Хүйс | Регистрийн дугаар | Сорьц авсан огноо | Тээвэрлэлтэд өгсөн огноо | Сорьц авсан аймаг, дүүрэг, эмнэлгийн нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/473 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

# ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ТАРХАЛТЫН ҮЕ ШАТЫГ ТОГТООХ ЗААВАР

1.1. Улс, нийслэл, аймгийн ТТӨ-ий тархалтын үе шатыг ДЭМБ-аас гаргасан "Улирлын томуу, томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээ (УТТЦХҮ)-ний аргачлалаар тодорхойлно.

1.2. ТТӨ-ий тархалтын үе шатыг "Улирал хоорондын үе", "Идэвхжлийн үе", "Алаг цоог дэгдэлтийн үе", "Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлт", "Тахалт тархалт" гэж 5 ангилна.

1.3. ТТӨ-ий тархалтын үе шатыг халдварлалт, хүндрэлийн зэрэг, үр нөлөө гэсэн 3 зэрэгт хуваагдах шалгуур үзүүлэлтээр тогтооно.

1.4. Шалгуур үзүүлэлт тус бүрийг тодорхойлохдоо өөрт тохирох хэмжүүрийг сонгоно (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийг тодорхойлоход хэрэглэгдэх хэмжүүр**

| Шалгуур үзүүлэлт | Хэмжүүр |
|---|---|
| Халдварлалтын зэрэг | – 10,000 хүн ам дахь ТТӨ<br>– Томуугийн вирус эерэг гарсан хувь<br>– 10,000 хүн ам дахь ТТӨ-ий тохиолдол буюу томуу эерэг гарсан хувийн нийлмэл утга |
| Хүндрэлийн зэрэг | – АЗЦХХ-ын нас баралт/АЗЦХХ-ын тохиолдол<br>– 10,000 хүн ам дахь АЗЦХХ/10,000 хүн ам дахь ТТӨ<br>– АЗЦХХ-ын доторх томуу эерэг гарсан хувь, ТТӨ доторх томуу эерэг гарсан хувь<br>– АЗЦХХ-ын нийлмэл утга / ТТӨ-ий нийлмэл утга |
| Үр нөлөө | – 10,000 хүн ам дахь АЗЦХХ-ын тохиолдол<br>– 10,000 хүн ам дахь ТТӨ болон томуу эерэг гарсан хувийн нийлмэл утга<br>– АЗЦХХ-ын шалтгаант орны ачаалал<br>– Эмийн сангийн борлуулалтын мэдээ |

1.5. Тархвар судлалын 7 хоног бүрийн өвчлөлийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт тус бүрээр гарган босго үзүүлэлттэй харьцуулж матрицаар үнэлэн ТТӨ-ий тархалтын үе шатыг тогтооно.

1.6. ТТӨ-ий тархалтын үе шатыг дараах шалгуурыг ашиглан тогтооно (Хүснэгт 2).

**Хүснэгт 2. Үе шат тодорхойлох шалгуур**

| Үе шат | Шалгуур |
|---|---|
| Улирал хоорондын үе | ТТӨ-ий идэвхжилгүй үеийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 2 долоо хоног дараалан доогуур байгаа тохиолдолд |
| Идэвхжлийн үе | "Улирал хоорондын" үеийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 2 долоо хоног дараалан давсан тохиолдолд |
| Алаг цоог дэгдэлтийн үе | "Идэвхжлийн үе"-ийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 2 долоо хоног дараалан давсан тохиолдолд |
| Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлт | "Алаг цоог дэгдэлтийн үе"-ийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 1 долоо хоног давсан тохиолдолд |
| Тахалт тархалт | "Улсын хэмжээний дэгдэлтийн үе"-ийг тодорхойлж буй босго үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлт нь 1 долоо хоног давсан тохиолдолд |

1.7. Аймгийн ЭМГ нь шалгуур үзүүлэлт тус бүрээр босго үзүүлэлтийг шинэчлэн, жил бүрийн 8 дугаар сард ХӨСҮТ-ийн ТҮН-д хүргүүлэн баталгаажуулна.

1.8. ХӨСҮТ-ийн ТҮН нь жил бүрийн 9 дүгээр сард улсын хэмжээний босго үзүүлэлтийг шинэчлэн гаргана.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 13-ны өдрийн А/373 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ТАРХАЛТЫН ҮЕ ШАТАНД ТОХИРСОН БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ

## Нэг. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв

| Хариу арга хэмжээний чиглэл | ТТӨ-ий тархалтын үе шат | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Улирал хооронд | Идэвхжил | Алаг цоог дэгдэлт | Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлт | Тахал тархалт |
| Тандалт, хариу арга хэмжээ | – ТТӨ-ий дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх;<br>– Улирлын томуугийн вакцинд хамрагдах эрсдэлт бүлгийн хүн амын судалгаар гаргах, дархлаажуулалтыг зохион байгуулах. | – ТТӨ-тэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх;<br>– Хүүхдийн байгууллагад ирцийн тандалт хийх;<br>– 30 болон түүнээс дээш хувиар ирц хангалтгүй байгаа сургууль, цэцэрлэгт мэргэжлийн баг томилон ажиллуулах. | – Идэвхжлийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– ТТӨ-тэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагаар эрчимжүүлэх;<br>– Эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн түвшин, идэвхжлийн зэрэгт тохируулан хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх;<br>– Олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран эмзэг бүлгийн иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх. | – Алаг цоог дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Сургууль, цэцэрлэгийг хаах, сурагчийн амралтыг сунгах, олон нийтийн арга хэмжээг хязгаарлах саналыг орон нутгийн засаг захиргааны байгууллагад хүргүүлэх;<br>– Дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтан, резидент эмч, анагаахын төгсөх дамжааны оюутнуудыг шаардлагатай газруудад хуваарилан, ажиллуулах. | – Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх;<br>– Аймаг, нийслэлийн Онцгой комиссыг хуралдуулж, хөл хорио тогтоох, үйлчилгээний байгууллагын цагийг хязгаарлах, хаах;<br>– Дэгдэлт болж буй газар нутагт шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулах; |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээ | – ТТӨ-ий дэгдэлтийн үед эмнэлгийн бус байранд ор дэлгэх байгууллагуудтай гэрээ хийх;<br>– Эмзэг бүлгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх газрыг төлөвлөн, бэлэн байдлыг хангах. | – ТТӨ-ий үүсгэгчийн онцлогоос хамаарч, АЗЦХХ-тай өвчтөний ялган оношилгооны талаар зөвлөмж гаргаж, харъяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангах. | – Идэвхжлийн үеийн арга хэмжээ НЭМЭХ:<br>– Төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран эмзэг бүлгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх байрыг | – Алаг цоог дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Шаардлагатай бол эмнэлгийн бус байранд ор дэлгэх;<br>– Амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгсдэд зориулсан амбулаторийг зохион | – Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Эмнэлзүйн менежментийг сайжруулах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөний дагуу нээн ажиллуулах. | байгуулж, төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг ажиллуулах;<br>– Эрүүл мэндийн ажилтан, резидент эмч, анагаахын төгсөх дамжааны оюутнуудыг хуваарийн дагуу шаардлагатай газруудад дайчлан ажиллуулах. | |
| Нөөцийн бэлэн байдлын хангалт | – Лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, түргэвчилсэн тест, нэмэлт ор, эмнэлэг дэлгэх, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тооцоог гарган, тухайн жилийн төсөвт тусгах;<br>– Дэгдэлтийн үед ажиллах хүний нөөцийн судалгааг гарган, үүрэгжүүлэх;<br>– Эрүүл мэндийн ажилтанг оношилгоо, эмчилгээ, тандалт, хариу арга хэмжээ, халдварын хяналт, сэргийлэлт, эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургаж, чадавхижуулах; | – ТТӨ-ий дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагад шаардагдах лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах; | – ТТӨ-ий дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагад шаардагдах лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах; | – ТТӨ-ий дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагад шаардагдах лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах; | – ТТӨ-ий дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагад шаардагдах лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах;<br>– Нэмэлт төсөв шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх. |
| Эрсдэлийн үеийн харилцаа холбоо | – Эрсдэлт бүлгийн хүн амыг чийрэгжүүлэх, дархлаажуулах чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийх;<br>– Эрсдэлийн үеийн харилцаа, холбооны төлөвлөгөө боловсруулах;<br>– Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах; | – Төр захиргааны байгууллага, хүүхдийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтнуудыг үнэн зөв мэдээллээр хангах;<br>– Аж ахуй нэгж, сургууль, хүүхдийн байгууллагад ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлэх; | – Идэвхжлийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Сайн дурын идэвхтэнийг эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн халамжийн ажилд дайчлан ажиллуулах;<br>– Нэлттэй утсыг ажлын цагаар ажиллуулж, халдварын шинж тэмдэгтэй | – Алаг цоог дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Эрсдэлийн үеийн харилцаа холбооны багийг идэвхжүүлж, бүх зорилтот бүлэгт мэдээлэл хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх;<br>– Хүн амын дундах ойлголт, хандлагыг судлах;<br>– Нөхцөл байдалд үндэслэн эрсдэлийн үеийн харилцаа | – Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ард иргэдэд түгээх; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | – ТТӨ-өөс сэргийлэх мессежний эх, агуулга боловсруулах;<br>– Цахим тандалт хийх;<br>– ТТӨ-ий сэргийлэх мэдээлэл сурталчилгааны материалаар мэдээллийн сан, архив үүсгэх. | – Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд тандалт хийж, эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлэн, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг гаргах;<br>– Иргэдэд ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, инфографик, зөвлөмж, видео танилцуулгыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх. | үйлчлүүлэгчид заавар, зөвлөмж өгөх;<br>– Цахим тандалт хийж, буруу ташаа мэдээлэлд зарлуулга хийх. | холбооны төлөвлөгөөг шинэчлэх;<br>– Шинээр боловсруулсан мессежний агуулгыг зорилтот хүн амын дунд турших;<br>– Нээлттэй утсыг 24 цагаар ажиллуулж, халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчид заавар, зөвлөмж өгөх. | – Хувь хүн, олон нийтийн түвшинд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр захиргааны байгууллага, сайн дурын идэвхтэнүүдтэй хамтран зохион байгуулах;<br>– Аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажлыг цахимаар явуулах, аль болох олон хүн бөөгнөрүүлэхгүй зэрэг тархалтыг бууруулах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэх. |

## Хоёр. Бусийн оношилгоо эмчилгээний төв, аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага

| Хариу арга хэмжээний чиглэл | ТТӨ-ий тархалтын үе шат | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Улирал хооронд | Идэвхжил | Алаг цоог дэгдэлт | Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлт | Тахал тархалт |
| Тандалт, хариу арга хэмжээ | – ТТӨ-ий дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, ор дэлгэх, зохицуулах төлөвлөгөөнд тодотгол хийх. | – Хариу арга хэмжээг идэвхжүүлэх;<br>– Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх. | – Бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу ажиллах;<br>– Хариу арга хэмжээг идэвхжүүлэх;<br>– Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх. | – Бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу ажиллах;<br>– Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх;<br>– Эрүүл мэндийн ажилтнуудын цагт зохицуулалт хийх, халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх | – Бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу ажиллах;<br>– Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх;<br>– Эрүүл мэндийн ажилтнуудын цагт зохицуулалт хийх, халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Эмнэлгийн тусламж үйлчилгээ | – Дэгдэлтийн үед эмнэлгийн тулсамж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, нэмэлтээр дайчилан ажиллуулах эрүүл мэндийн ажилтны хуваарийг гарган, үүрэгжүүлэх. | – Хүүхэд, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн ор, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах;<br>– Томуугийн вирус хүн амын дунд орчилд орсон үед лабораторийн шинжилгээний хариу хүлээлгүйгээр вирусийн эсрэг эм (тамифлю)-ийг хүндэрч болзошгүй өвчтөнд хэрэглэх;<br>– Халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг эрчимжүүлэх;<br>– Халдварын шинж тэмдэгтэй өвчтөнг ТТӨ-ий бус шалтгаанаар эмнэлэгт хандаж байгаа үйлчлүүлэгчтэй хавьтал болохоос сэргийлж эмнэлгийн урсгал, зохион байгуулалтыг төлөвлөх, үйлчлүүлэгчдийг эрэмбэлэн ангилах;<br>– Бүх тасагт тусгаарлах өрөөг гаргаж, халдварын шинж тэмдэгтэй өвчтөнг тусгаарлан, онош тодруулах;<br>– Амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчдэд түргэвчилсэн тест тавьж, оношийг яаралтай тодруулан, эмчилгээг эрт эхлүүлэх;<br>– Үйлчлүүлэгсдэд амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих, гар | – Идэвхжлийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Орны зохицуулалтыг хийж, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн тоног төхөөрөмж, эрүүл мэндийн ажилтныг нэмэгдүүлэх;<br>– Тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангах;<br>– Түргэн тусламжийн машин, эмч нарын тоог нэмэгдүүлж, амбулаторийг уртасгасан цагаар ажиллуулах;<br>– Дайчлан ажиллуулах эрүүл мэндийн ажилтан, резидент эмч нарыг шаардлагатай тасгуудад томилон ажиллуулах;<br>– Эргэлтийн цагийг багасгах, сахиурын тоог цөөлж, шаардлагагүй тохиолдолд солихгүй байх, эргэлтийн үед халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэх;<br>– Амбулатори, хүлээн авах яаралтай тусламжийн тасагт ТТӨ болон АЗЦХХ-тай өвчтөнд үзлэг хийх өрөөг эмнэлгийн орох, гарах хаалгатай ойр, хөл хөдөлгөөнөөс зайдуу, агааржуулалт сайтай, гарын угаагуууртай хэсэгт, бусад үйлчлүүлэгчидтэй хавьтал болохооргүй байхаар зохион байгуулж, өрөө болгонд амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодис байрлуулах. | – Алаг цоог дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Жирэмсний үзлэг, хяналт, бага насны хүүхдийн товлолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусламж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлэх;<br>– Өвчтөнийг эрэмбэлэн ангилж, эрүүл мэндийн байгууллага дээр бөөгнөрөл үүсгэхгүй байх;<br>Эмнэлэгт хэвтэх шалгуурыг нарийвчлан, эмнэлгээс гарсан, гэрээр эмчлэгдэж байгаа өвчтөний хяналт, эргэлтийг эрчимжүүлэх. | – Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Аль болох өөр өвчтөнтэй хавьтал болохооргүй өрөө, тасгийг сонгон, үйл ажиллагааг түр зогсоож, хүүхдийн орны тоог нэмэгдүүлэн, хүүхдийн тусламж үйлчилгээнд шилжүүлэх;<br>– Сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг, лабораторийн хүчин чадлыг үнэлэн, шаардлагатай бол хүчин чадлыг нэмэгдүүлэх;<br>– Харьяа нутаг дэвсгэрт байрлаж байгаа хувийн оргүй эмнэлэгт зарим амбулаторийн үйлчилгээг шилжүүлэх. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлж, зурагт хуудас, санамжийг байршуулах. | | | |
| Нөөцийн бэлэн байдлын хангалт | – ТТӨ-ий дэгдэлтийн үед шаардагдах лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, нэмэлт ор, эмнэлэг дэлгэх, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тооцоог гарган, тухайн жилийн төсөвт тусгаж, нөөцийг бүрдүүлэх;<br>– Дэгдэлтийн үед ажиллах хүний нөөцийн судалгаа гарган, үүрэгжүүлэх;<br>– Эмч, мэргэжилтнүүдийг оношилгоо, эмчилгээ, тандалт, хариу арга хэмжээ, халдварын хяналт, сэргийлэлт, эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургаж, чадавхижуулнах. | – Эмч нарт томуугийн вирусийн онцлог, эмнэлзүйн менежмент, вирусийн эсрэг эм бэлдмэлийн хэрэглээний талаар (телемедицин, алсын зайн) сургалт зохион байгуулах;<br>– Лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах. | – Лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах. | – Лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах. | – Лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодис, хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөц, тоног төхөөрөмжийн тасралтгүй байдлыг хангах. |
| Эрсдэлийн үеийн харилцаа холбоо | – Эрсдэлт бүлгийн хүн амыг чийрэгжүүлэх, дархлаажуулах чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийх;<br>– Эрсдэлийн үеийн харилцаа, холбооны төлөвлөгөө боловсруулах;<br>– Олон нийтийн хэвлэл мэдээллийн | – Аж ахуй нэгж, сургууль, хүүхдийн байгууллагад ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлэх;<br>– Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд тандалт хийж, эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлэн, өдөр тутмын нөхцөл | – Идэвхжлийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Нээлттэй утсыг ажлын цагаар ажиллуулж, халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчид заавар, зөвлөмж өгөх; | – Алаг цоог дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Нөхцөл байдалд үндэслэн эрсдэлийн үеийн харилцаа холбооны төлөвлөгөөг шинэчлэх;<br>– Шинээр боловсруулсан мессежний агуулгыг | – Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ард иргэдэд түгээх;<br>– Аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажлыг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэгсэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах;<br>– ТТӨ-өөс сэргийлэх мессежний эх, агуулга боловсруулах;<br>– Цахим тандалт хийх;<br>– ТТӨ-ий сэргийлэх мэдээлэл сурталчилгааны материалаар мэдээллийн сан, архив үүсгэх. | байдалтай уялдуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг гаргах;<br>– Иргэдэд ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, инфографик, зөвлөмж, видео танилцуулгыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх. | – Цахим тандалт хийж, буруу ташаа мэдээлэлд зарлуулга хийх. | зорилтот хүн амын дунд турших;<br>– Нээлттэй утсыг 24 цагаар ажиллуулж, халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчид заавар, зөвлөмж өгөх. | цахимаар явуулах, аль болох олон хүн бөөгнөрүүлэхгүй зэрэг тархалтыг бууруулах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэх. |

## Гурав. Өрх, сумын Эрүүл мэндийн төв

| Хариу арга хэмжээний чиглэл | ТТӨ-ий тархалтын үе шат | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Улирал хооронд | Идэвхжил | Алаг цоог дэгдэлт | Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлт | Тахал тархалт |
| Тандалт, хариу арга хэмжээ | – ТТӨ-ий дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх;<br>– Шувуу, гахайны аж ахуй эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг шинэчлэх;<br>– Эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг шинэчлэх. | – Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх; | – Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх; | – Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх; | – Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчийн дунд эмнэлзүйн тандалтыг өдөр бүр хийх; |
| Эмнэлгийн тусламж, үйлчилгээ | – Эмнэлгийн тулсамж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн | – Халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг эрчимжүүлэх;<br>– Халдварын шинж тэмдэгтэй өвчтөнг ТТӨ- | – Идэвхжлийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Амбулаторийг уртасгасан цагаар ажиллуулах; | – Алаг цоог дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Жирэмсний үзлэг, хяналт, бага насны | – Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэгсэл, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, холбогдох байгууллагатай гэрээ байгуулах. | ий бус шалтгаанаар эмнэлэгт хандаж байгаа үйлчлүүлэгчтэй хавьтал болохоос сэргийлж эмнэлгийн урсгал, зохион байгуулалтыг төлөвлөх, үйлчлүүлэгчдийг эрэмбэлэн ангилах;<br>– Амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй өвчтөнийг тусгаарлах өрөөнд тусгаарлаж, үзлэг хийж, онош тодруулах;<br>– Амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчдэд түргэвчилсэн тест тавьж, оношыг яаралтай тодруулан, эмчилгээг эрт эхлүүлэх;<br>– Үйлчлүүлэгсдэд амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих, гар халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлж, зурагт хуудас, санамжийг байршуулах;<br>– Үйлчлүүлэгчийн эмнэлэгт ирэх хөдөлгөөнийг бууруулж, байнгын хяналтанд байдаг зорилтот бүлгийн иргэнд цахимаар зөвлөлгөө өгөх, гэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх. | – Эрсдэлт бүлгийн хүн амын өрхийн эмчийн үзлэгийг гэрийн эргэлтэнд шилжүүлж, хөнгөн болон дунд хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг гэрээр эмчлэх;<br>– Амбулаторид ТТӨ болон АЗЦХХ-тай өвчтөнд үзлэг хийх өрөөг эмнэлгийн орох, гарах хаалгатай ойр, хөл хөдөлгөөнөөс зайдуу, агааржуулалт сайтай, гарын угаагууртай хэсэгт, бусад үйлчлүүлэгчидтэй хавьтал болохооргүй байхаар зохион байгуулж, өрөө болгонд амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодис байрлуулах.<br>– Амбулаторид "Хөтөч сувилагч" ажиллуулж, "Дуугүй хөтөч" байрлуулах. | хүүхдийн товлолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусламж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлэх, үйлчлүүлэгчийн нягтралыг бууруулах;<br>– Эмнэлэгт хэвтүүлэх шалгуурыг нарийвчлан, шаардлагагүй хэвтэлтийг багасгаж, эмнэлгээс гарсан, гэрээр эмчлэгдэж байгаа өвчтөний хяналт, эргэлтийг эрчимжүүлэх; | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Нөөцийн бэлэн байдлын хангалт | – ТТӨ-ий дэгдэлтийн үед шаардагдах хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тестийн тооцоог гарган, тухайн жилийн төсөвт тусгаж, нөөцийг бүрдүүлэх;<br>– Дэгдэлтийн үед ажиллах хүний нөөцийн судалгааг гарган, үүрэгжүүлэх;<br>– Эмч, мэргэжилтнүүдийг оношилгоо, эмчилгээ, тандалт, хариу арга хэмжээ, халдварын хяналт, сэргийлэлт, эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургаж, чадавхижуулах. | – ТТӨ-ий дэгдэлтийн үед хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангах; | – ТТӨ-ий дэгдэлтийн үед хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангах; | – ТТӨ-ий дэгдэлтийн үед хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангах; | – ТТӨ-ий дэгдэлтийн үед хувийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, түргэвчилсэн тест, хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангах;<br>– Нэмэлт төсөв шаардлагатай бол тооцоолол хийж, удирдах дээд байгууллагад илгээх. |
| Эрсдэлийн үеийн харилцаа холбоо | – Эрсдэлт бүлгийн хүн амыг чийрэгжүүлэх, дархлаажуулах чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийх;<br>– Эрсдэлийн үеийн харилцаа, холбооны төлөвлөгөө боловсруулах;<br>– ТТӨ-өөс сэргийлэх мессежний эх, | – Төр захиргааны байгууллага, хүүхдийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтнуудыг үнэн зөв мэдээллээр хангах;<br>– Аж ахуй нэгж, сургууль, хүүхдийн байгууллагад ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлэх; | – Идэвхжлийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Сайн дурын идэвхтэнийг эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн халамжийн ажилд дайчлан ажиллуулах;<br>– Цахим тандалт хийж, буруу ташаа мэдээлэлд зарлуулга хийх. | – Алаг цоог дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Нөхцөл байдалд үндэслэн эрсдэлийн үеийн харилцаа холбооны төлөвлөгөөг шинэчлэх. | – Улс (аймаг)-ын хэмжээний дэгдэлтийн үеийн арга хэмжээ НЭМЭХ;<br>– Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ард иргэдэд түгээх;<br>– Хувь хүн, олон нийтийн түвшинд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | агуулга боловсруулах;<br>– Цахим тандалт хийх;<br>– ТТӨ-ий сэргийлэх мэдээлэл сурталчилгааны материалаар мэдээллийн сан, архив үүсгэх. | – Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд тандалт хийж, эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлэн, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг гаргах;<br>– Иргэдэд ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, инфографик, зөвлөмж, видео танилцуулгыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх. | | | захиргааны байгууллага, сайн дурын идэвхтэнүүдтэй хамтран зохион байгуулах;<br>– Аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажлыг цахимаар явуулах, аль болох олон хүн бөөгнөрүүлэхгүй зэрэг тархалтыг бууруулах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэх. |

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
07 дугаар сарын 18-ны өдрийн А/373 дугаар
тушаалын тавдугаар хавсралт

ЛАБОРАТОРИД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН
ЗААВАР

**Нэг. Тавигдах шаардлага**

1.1. ТТӨ, АЗЦХХ-ын тохиолдлыг оношилсон эмч эмчилгээ эхлэхээс өмнө өвчтөнөөс сорьц авна.

1.2. Лабораторийн шинжилгээнд хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, амьсгалын доод замын хүнд хэлбэрийн өвчтөнөөс цэр, амьсгалын гуурстай өвчтөнөөс мөгөөрсөн хоолойн сордос, мөгөөрсөн хоолой-альвеолын лаваж, нас барсан тохиолдолд уушгины эд авна.

1.3. Сорьц авах үед өрөөнд байх хүний тоог хязгаарлаж, зөвхөн үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтныг байлцуулна.

1.4. Шинжлэгдэхүүн авах эрүүл мэндийн ажилтан нь хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн өмсч, шүүлтүүр бүхий N95 амны хаалт, нүдний шил эсвэл нүүрний хаалт зүүнэ.

**Хоёр. Сорьц цуглуулах**

2.1. Бамбараар сорьц авахдаа "үзэг барилт"-ын техник ашиглана. Бамбарын иш хэсгийн хугарах ховилтой хэсгээс хойш барина.

2.2. Хамар-залгиурын арчдас цуглуулах: Үйлчлүүлэгчийн нусыг нийлгэх буюу ариутгасан бамбараар хамрын хөндийг арчиж цэвэрлээд, насанд хүрэгсдийг хэвтээ эсвэл толгойг 45° өнцгөөр гэдийлгэж, хүүхдийг асран хамгаалагчид нь хөдөлгөөнгүй тэврүүлэн суулгана. Бамбарыг хамрын хөндийн доод хэсгийг дагуулан зөөлөн тагнайтай параллелаар оруулж салст бүрхүүлд зөөлөн шахаж эргүүлээд сугалж авна. Бамбарыг вирус тээвэрлэх стандарт орчин бүхий хуруу шилэнд хийж, бамбарын ишийг ховил хэсгээр болгоомжтой хугалж хаяад хуруу шилийг сайтар таглана. Хамрын хөндийд бамбарыг оруулах үед саад учирвал хүчлэхгүй, эргүүлэх хөдөлгөөнөөр саадыг давах эсхүл ажилбарыг зогсооно.

2.3. Ам-залгиурын арчдас цуглуулах: Үйлчлүүлэгчийг дээрх байдлаар бэлтгэж, суулгаад хатуу иштэй ариун бамбар ашиглан хэл дарагчаар хэлийг дарж, залгиурын арын ханыг бамбараар зөөлөн дарж арчиж авна. Бамбарыг вирус тээвэрлэх стандарт орчин бүхий хуруу шилэнд хийж сайтар таглана.

2.4. Цэр цуглуулах: Үйлчлүүлэгчийн амыг усаар сайтар зайлуулж, амны хөндийг цэвэрлэн, хамар ба хоолойн салс, шүлс зэргийг аль болох оруулахгүй цэр авна. Амьсгалыг гүнзгий авахуулж түгжин 2 секунд орчим болсны дараа аажим гаргуулж, энэ үйлдлийг 2-оос доошгүй удаа давтана. Гурав дахь удаагаа амьсгалыг гүнзгий авахуулж, хүчтэй ханиалгуулан цээжний гүнээс цэрийг гаргуулна. Гаргасан цэрийг цэр цуглуулах зориулалтын ариун саванд хийнэ. Цэрний хэмжээ 3-5 мл байна.

2.5. Эд, эсийн сорьц цуглуулах: Нас барсан тохиолдолд уушгины эдийн гүнээс буюу гуурсан хоолойноос 0.5 см талтай шоо хэлбэртэй зүсмэг авч, хуурай ариун саванд хийж сайтар таглана.

**Гурав. Сорьц хадгалах, тээвэрлэх**

3.1. Сорьцыг гэрээт тээврийн компаниар лабораторид хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд тухайн эрүүл мэндийн байгууллага сорьцыг лабораторид хүргэнэ.

3.2. Хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, мөгөөрсөн хоолойн сордос, эдийн сорьцыг 24-48 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, +2-оос +8 хэмд тээвэрлэж, лабораторид хүргүүлнэ. Хэрэв 48 цагийн дотор тээвэрлэх боломжгүй бол - 70°С хэмийн гүн хөлдөөгчид хадгалж, хөлдүү байдалтай тээвэрлэн лабораторид хүргүүлнэ.

3.3. Сорьцыг тээвэрлэхийн өмнө ХӨСҮТ-ийн Вирус судлалын лавлагаа лабораторийн 455847, 451183 дугаарын утсаар, орон нутагт харъяа лабораторид урьдчилан мэдэгдэнэ.

3.4. Сорьцыг асгарахаас сэргийлэн биоаюултай илгээмж, биобэлдмэл тээвэрлэх журмын дагуу гурвалсан баглааны зарчмыг баримтална. Сорьц цуглуулсан савны гадуур амыг нь битүүмжлэх боломж бүхий уутанд хийж, гадна талд нь "Биоаюултай", "Халдвартай" гэсэн тэмдэглэгээг хийж тээвэрлэнэ. Сорьцыг шингээгч цаас болон самбайгаар ороон жийрэглэж хоёрдогч саванд хийнэ. Хэд хэдэн сорьцыг хоёрдогч саванд хийж болно. Ингэхдээ тус тусад нь шингээгч материалаар ороонo. Уг сорьцоо тусгай пластик саванд хөдөлгөөнгүй байрлуулж таглаад мөсөн элемент бүхий гуравдагч саванд сорьцыг босоо байрлуулна. Савны дотор +2-оос +8 хэмийн хүйтэн хэлхээг баримтлан хянах зорилгоор термометр байрлуулна.

3.5. Сорьц дагалдах хуудсыг зөв, гаргацтай бөглөж сорьцын хамт илгээнэ (Маягт 6).

3.6. Тээвэрлэхийн өмнө сорьцын мэдээллийг ИСТМС (http://fis.flu.mn)-д бүртгэж, шинжилгээний хариуг ИСТМС (http://fis.flu.mn)-ээс авна.

**Дөрөв. Шаардагдах хэрэгсэл**

4.1. Хамгаалах хувцас хэрэгсэл (шингэн үл нэвтрүүлэх материалаар хийгдсэн халад, N95 амны хаалт, нүдний шил эсвэл нүүрний хаалт, бээлий)

4.2. 7-8 см урт уян болон хатуу иштэй ариун бамбар

4.3. Хэл дарагч

4.4. Вирус зөөвөрлөх стандарт орчин

4.5. Хуруу шил тавиур

4.6. Цэрний сав

4.7. Сорьц тээвэрлэх зориулалтын сав

4.8. Мөсөн элемент

4.9. Сорьцын дагалдах хуудас

4.10. Шилний харандаа

4.11. Хуурай салфетка

4.12. Термометр

4.13. Гар халдваргүйжүүлэгч

4.14. Хог хаягдлын сав

**Тав. Томуу, SARS-CoV-2 вирусийн хувилбарын тандалт хийх:**

5.1. Лабораторийн шалгуур үзүүлэлт:

5.1.1. Бх-ПГУ шинжилгээгээр эерэг тодорхойлогдсон, CT утга 25-аас доош байх;

5.1.2. 0-18, 19-59, 60< насны бүлэг тус бүрээс 4-өөс доошгүй сорьц байх;

5.1.3. Сорьцыг -70 хэмийн гүн хөлдөөгчид хадгалсан байх.

5.2. Тархварзүй, эмнэлзүйн шалгуур үзүүлэлт:

5.2.1. ТТӨ болон SARS-CoV-2 вирус орчилд ороогүй үед амьсгалын замын халдварын шинж тэмдэг бүхий бүх тохиолдлыг хамруулна.

5.2.2. ТТӨ болон SARS-CoV-2 вирус орчилд орсон үед дараах нэмэлт шалгуураар сорьц авч шинжилнэ. Үүнд:

5.2.2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аар давтан өвчилсөн тохиолдол;

5.2.2.2. Дархлаа дарангуйлагдсан хүнд амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдол;

5.2.2.3. Эмнэлзүйн өвөрмөц шинж тэмдэг бүхий тохиолдлын кластер;

5.2.2.4. АЗЦХХ-ын шалтгаантай хүнд, маш хүнд эсвэл нас барсан тохиолдол;

5.2.2.5. SARS-CoV-2 вирусийн шинэ хувилбар илэрсэн улс орон эсвэл аймаг, орон нутгаар сүүлийн 14 хоногт зорчсон иргэн.

**Зургаа. Хувилбарын тандалтад сорьц илгээх, мэдээлэх:**

6.1. Бүсийн болон салбар лаборатори нь SARS-CoV-2 вирус илрүүлэх бх-ПГУ-ын шинжилгээний эерэг тохиолдлоос тандалтын сорьцод тавигдах шаардлагыг хангасан 10 хүртэлх сорьцыг сонгож, тээвэрлэх заавры г баримтлан 7-14 хоногт вирус судлалын лавлагаа лабораторид хүргүүлнэ.

6.2. Томуугийн вирус илрүүлэх бх-ПГУ-ын шинжилгээ хийж, эерэг тохиолдлоос 10 хүртэлх сорьцыг сонгож, тээвэрлэх зааврыг баримтлан 7-14 хоногт нэг удаа вирус судлалын лавлагаа лабораторид хүргүүлнэ.

6.3. Хилийн нэвтрэх цэг дэх тандалтын нэмэлт нэгж нь хилийн боомтын ажилтнаас 10 сорьц, суурьшлын бүсийн хүн амаас 10 сорьцыг 14 хоногт нэг удаа (0-18, 16-59, 60 болон түүнээс дээш насны бүлгийг төлөөлөхүйц байх) цуглуулж, вирус судлалын лавлагаа лабораторид 72 цагийн дотор хүргүүлнэ.

6.4. Хилийн нэвтрэх цэг дэх тандалтын нэмэлт нэгжийн авсан сорьцыг тухайн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн сорьц тээвэрлэх журмыг баримтлан вирус судлалын лавлагаа лабораторид хүргүүлнэ.

6.5. Бүсийн болон салбар лаборатори нь сорьцыг -70°C хэмийн гүн хөлдөөгчид цэгцтэй хадгалж, бүртгэлжүүлнэ. Лавлагаа лабораторид сорьцыг дагалдах хуудас (Маягт 7)-ын хамт хөлдүү байдлаар илгээнэ.

6.6. Сорьцын мэдээллийг "Маягт 8"-д заасны дагуу "Microsoft Excel" программд шивж, virologylabmng@nccd.gov.mn хаягаар лавлагаа лабораторид илгээнэ.

6.7. Хувилбарын тандалтын шинжилгээний хариуг ХӨСҮТ-ийн Вирус судлалын лавлагаа лаборатори нь Томуугийн үндэсний нэгжид nicmongolia@nccd.gov.mn цахим хаягаар мэдээлэх ба сорьц ирүүлсэн Вирус судлалын лабораторид эргэн мэдээллийг цахим хаягаар хүргүүлнэ.

## Маягт 7. Сорьц дагалдах хуудас №....../.......

Эрүүл мэндийн байгууллагын нэр ....................................................
Өвчтөний овог/нэр ...................................................................................
Нас: ........, Хүйс: Эрэгтэй I__I , Эмэгтэй I__I
Гэрийн хаяг: ............................................................................................
Эмнэлзүйн онош: ......................................................................................
Өвчин эхэлсэн огноо: _______ оны ___ сарын __ өдөр
Эмнэлэгт хэвтсэн огноо: _______ оны ___ сарын __ өдөр
Сорьц цуглуулсан огноо: _______ оны ___ сарын __ өдөр ___цаг __минут
Сорьц авах үеийн биеийн хэм: I__I__I.I__I °C
Цуглуулсан сорьцын төрөл: Хамар-залгиурын арчдас I__I
Ам-залгиурын арчдас I__I
Мөгөөрсөн хоолойн сордос I__I
Бусад ................................ I__I
Сорьцыг тээвэрлэлтэд өгсөн: огноо: _______ оны ___ сарын __ өдөр ___цаг __минут
Сорьц авсан эмч, сувилагчийн нэр: .........................................................................

## Маягт 8. SARS-CoV-2-ын хувилбарын тандалтын сорьцын дагалдах хуудас

| **Сорьцын мэдээлэл:** |
|---|
| Сорьцын тусгай дугаар: I_I_I_I_I_I_I_I_I_I_I_I_I_I |
| Сорьцын төрөл:I_IХамар-залгиурын арчдас; I_IАм-залгиурын арчдас; I_IЦэр; I_IЭд, эсийн сорьц |
| Сорьц цуглуулсан огноо: I_I_I_I_I-I_I_I-I_I_I |
| Сорьц цуглуулсан аймаг/хотын нэр: ____________________ |
| Анх оношилсон лабораторийн нэр:____________________ |
| Геномын дараалал тогтоосон лабораторийн нэр: ____________________ |
| Түүвэрлэлтийн арга:<br>I_IХүн амын дундаас; I_IӨвөрмөц тохиолдлоос; I_IТандалтын зорилгоор /шинж тэмдэгтэй үйлчлүүлэгч/ |
| Хүн ам зүй, аяллын мэдээлэл: |
| НасI_I_I; Хүйс: I_I эр; I_I эм |
| Үндэс, угсаа: ____________________ |
| Эрүүл мэндийн ажилтан эсэх: I_Iтийм; I_Iүгүй |
| Аяллын түүх: сүүлийн 14 хоногт зорчсон газрууд: ____________________ |
| **Өвчтөний мэдээлэл:** |
| Ашигласан бх-ПГУ шинжилгээний төрөл (хэрэв ашигласан бол): ____________________ |
| бх-ПГУ СТ утга (хэрвээ байгаа бол): ____________________ |
| Шинж тэмдэгтэй эсэх: I_I тийм; I_I үгүй<br>Тийм бол шинж тэмдэг эхэлсэн огноо: I_I_I_I_I-I_I_I-I_I_I<br>Тийм бол шинж тэмдгийг бичих: ____________________ |
| Вакцинжуулалт:<br>1-р тунгийн огноо: I_I_I_I_I-I_I_I-I_I_I<br>2-р тунгийн огноо: I_I_I_I_I-I_I_I-I_I_I<br>3-р тунгийн огноо: I_I_I_I_I-I_I_I-I_I_I<br>4-р тунгийн огноо: I_I_I_I_I-I_I_I-I_I_I |
| Эмнэлэгт хэвтсэн эсэх: I_I тийм; I_I үгүй<br>Тийм бол огноо: I_I_I_I_I-I_I_I-I_I_I |
| Эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлсэн эсэх: I_I тийм; I_I үгүй<br>Тийм бол огноо:I_I_I_I_I-I_I_I-I_I_I |
| Механик вентиляци хийлгэсэн эсэх: I_I тийм; I_I үгүй<br>Тийм бол үр дүн:____________________ |
| Өмнө нь SARS-CoV-2 халдвар авсан эсэх<br>Тийм бол огноо:I_I_I_I_I-I_I_I-I_I_I |
| Тухайн үед хийлгэсэн эмчилгээг<br>бичих:____________________ |
| Кластер өвчлөлтэй холбоотой эсэх: I_I тийм; I_I үгүй |

| |
|---|
| Тийм бол кластерын нэр, төрөл: ______________________________ <br> Кластерт бүртгэгдсэн тохиолдлын тоо: ____________________ |
| Тээгч амьтантай харьцсан эсэх: : I_I тийм; I_I үгүй <br> Тийм бол ямар амьтан /бичих/: ______________________ |
| Хавсарсан өвчинтэй эсэх: I_I тийм; I_I үгүй <br> Тийм бол /бичих/: ________________________________________ |

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 13-ны өдрийн А/373 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

# ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН НЭГЖ, ВИРУС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН ЖАГСААЛТ

## Нэг. Амбулаторид суурилсан тандалтын нэгж

| № | Аймаг, сум | Өрх, сумын эрүүл мэндийн төв |
|---|---|---|
| | **1. Нийслэл** | |
| 1 | Багануур дүүрэг | Энэрэлт-Өлзий |
| 2 | | Биваангирд |
| 3 | | Ач элбэрэл |
| 4 | | Энх өрх |
| 5 | Баянгол дүүрэг | Шар дэгд |
| 6 | | Итгэл угтах |
| 7 | | Гурвансанчир |
| 8 | Баянзүрх дүүрэг | Амгалан Итгэлэхүй |
| 9 | | Насан-Урт |
| 10 | | Эрүүл өрх |
| 11 | Налайх дүүрэг | Амь эрдэнэ |
| 12 | Сүхбаатар дүүрэг | Тэгш мэнд |
| 13 | | Энхсүндэр |
| 14 | | Санколл |
| 15 | Сонгинохайрхан дүүрэг | Буянтманал |
| 16 | | Энхэлбэрэл |
| 17 | | Өнө ачит |
| 18 | Хан-Уул дүүрэг | Манал үйлс |
| 19 | | Амин тус |
| 20 | | Энхтитэм |
| 21 | Чингэлтэй дүүрэг | Үйлс нэгтэн |
| 22 | | Шэжид-дуг |
| 23 | | Тэгш өлзий |
| | **2. Орон нутагт** | |
| 24 | Архангай | Ар мөнхжин |
| 25 | | Ар мөнгөн чагнуур |
| 26 | | Ар манал |
| 27 | Баян-Өлгий | Жансая |
| 28 | | Мейрим |
| 29 | | Рауан |
| 30 | | Шипагер |
| 31 | Баянхонгор | Наран мандмал |
| 32 | | Оточ мандал |
| 33 | | Энхбүрд |
| 34 | | Оточ номгон |
| 35 | Булган | Цоожид |
| 36 | | Эмийнцэцэглэн |
| 37 | Говь-Алтай | Жаргалан алтай |
| 38 | | Марал алтай |
| 39 | | Энх-Алтай |

| | | |
|---|---|---|
| 40 | Говьсүмбэр | Энх тус дэм |
| 41 | Дархан | МЭДС ТОБ |
| 42 | | Гэрэлтэй |
| 43 | | Тувшинхолбоо |
| 44 | | Аминхолбоо |
| 45 | | Гос хот |
| 46 | Дорноговь | Агатова |
| 47 | | Мишээлт мана |
| 48 | | Төмөр зам |
| 49 | ДГ- Замын-Үүд | Борхойн наран |
| 50 | Дорнод | Асралт-үйлс |
| 51 | | Мянган жаргалан |
| 52 | | Ягаан цээнэ |
| 53 | Дундговь | Боржгон мандал |
| 54 | | Өлзийт мандал |
| 55 | | Сайнцагаан |
| 56 | Завхан | Биндэргарав |
| 57 | | Дөрвөн оноо |
| 58 | | Мөнхийн алба |
| 59 | Орхон | Нийцэл |
| 60 | | Мэндцэцэн |
| 61 | | Учралтбаяр |
| 62 | | Мөнхсүндрэл |
| 63 | | Мөнхийн гэгээ |
| 64 | | Үйлсбадрах |
| 65 | | Анхны оч |
| 66 | | Энхжин мандирваа |
| 67 | Өвөрхангай | Нарны дөш |
| 68 | | Түшиг дэлгээн |
| 69 | | Уян сэтгэл |
| 70 | ӨВ-Хархорин | Энэрэлт хархорин |
| 71 | Өмнөговь | Шим билэг |
| 72 | | Энхийн хүслэн |
| 73 | | Өнө орших |
| 74 | Сүхбаатар | Энхжин |
| 75 | | Энэрэл |
| 76 | | Тэмүүлэн |
| 77 | Сэлэнгэ | Номтхан |
| 78 | | Эмнэх |
| 79 | СЭ-Мандал | Баян |
| 80 | | Бату |
| 81 | | Ачит баг |
| 82 | СЭ-Алтанбулаг | Алтанбулаг |
| 83 | Төв | Баруун зуун мод |
| 84 | Увс | Элбэг-Өгөөж |
| 85 | | Дунцагаан |
| 86 | | Мөнхбишрэлт |
| 87 | | Батүржихүй |
| 88 | Ховд | Рашаант |
| 89 | | Жаргалант |
| 90 | | Бугат |
| 91 | | Баатархайрхан |
| 92 | | Буянт |

| | | |
|---|---|---|
| 93 | Хөвсгөл | Энх-Үйлс |
| 94 | | Далай-Элбэрэлт |
| 95 | | Дэлгэрмөрөн |
| 96 | | Гурван гал |
| 97 | | Энэрэл |
| 98 | Хэнтий | Хэрлэн дом |
| 99 | | Ач манал |
| 100 | | Оюуны шим |

## Хоёр. Эмнэлэгт суурилсан томуугийн харуулдан тандалтын нэгж

| № | Ангилал | Тандалтын нэгжийн нэр |
|---|---|---|
| 1 | Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв |
| 2 | | Халдварт өвчин судлалын үндэсний төв |
| 3 | | Улсын Клиникийн 1-р эмнэлэг |
| 4 | | Шастины нэрэмжит нэгдсэн 3-р эмнэлэг |
| 5 | | Хавдар судлалын үндэсний төв |
| 6 | | Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II |
| 7 | Бүсийн оношилгоо эмчилгээний төв | Дорнод |
| 8 | | Орхон |
| 9 | | Өвөрхангай |
| 10 | | Өмнөговь |
| 11 | | Ховд |
| 12 | Нэгдсэн эмнэлэг | Баянзүрх дүүрэг |
| 13 | | Хан-Уул дүүрэг |
| 14 | | Сүхбаатар дүүрэг |
| 15 | | Сонгинохайрхан дүүрэг |
| 16 | | Баянгол дүүрэг |
| 17 | | Чингэлтэй дүүрэг |
| 18 | | Багануур дүүрэг |
| 19 | | Налайх дүүрэг |
| 20 | | Багахангай дүүрэг |
| 21 | | Архангай |
| 22 | | Баян-Өлгий |
| 23 | | Баянхонгор |
| 24 | | Булган |
| 25 | | Говь-Алтай |
| 26 | | Говьсүмбэр |
| 27 | | Дархан-Уул |
| 28 | | Дорноговь |
| 29 | | Дундговь |
| 30 | | Завхан |
| 31 | | Сүхбаатар |
| 32 | | Сэлэнгэ |
| 33 | | Төв |
| 34 | | Увс |
| 35 | | Хөвсгөл |
| 36 | | Хэнтий |
| 37 | Сумын Нэгдсэн эмнэлэг | Дорноговь, Замын-Үүд сум |
| 38 | | Өвөрхангай, Хархорин сум |
| 39 | | Сэлэнгэ, Мандал сум |

## Гурав. Тандалтын нэмэлт нэгж

| № | Нэгжийн нэр | Хилийн боомт | Сумын нэр |
|---|---|---|---|
| 1 | Баян-Өлгий | Цагааннуур | Цагааннуур |
| 2 | Дорноговь | Замын-Үүд | Замын-Үүд |
| 3 | | Ханги | Хатанбулаг |
| 4 | Дорнод | Хавирга | Чойбалсан |
| 5 | | Эрээнцав | Чулуунхороот |
| 6 | | Баянхошуу | Халхгол |
| 7 | Өмнөговь | Гашуунсухайт | Ханбогд |
| 8 | | Шивээхүрэн | Гурван тэс |
| 9 | Сүхбаатар | Бичигт | Эрдэнэцагаан |
| 10 | Сэлэнгэ | Алтанбулаг | Алтанбулаг |
| 11 | | Сүхбаатар | Сүхбаатар |
| 12 | Увс | Боршоо | Давст |
| 13 | Ховд | Булган | Булган |
| 14 | Хөвсгөл | Ханх | Ханх |
| 15 | Улсын 2-р төв эмнэлэг | | |
| 16 | Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг | | |
| 17 | Цэргийн төв эмнэлэг | | |
| 18 | Улаанбаатар Төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн төв эмнэлэг | | |

## Дөрөв. Вирус судлалын лаборатори

| Лаборатори | Байршил |
|---|---|
| Вирус судлалын лавлагаа лаборатори | Халдварт өвчин судлалын үндэсний төв |
| Вирус судлалын бүсийн лаборатори | Дорнод, Орхон, Ховд, Өвөрхангай, Өмнөговь аймаг |
| Вирус судлалын салбар лаборатори | Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий, Сэлэнгэ |
| | Нийслэлийн Багануур, Баянзүрх, Баянгол, Налайх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг |

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/393 дугаар тушаалын долоодугаар хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫГ МЭДЭЭЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ЗААВАР

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээ үзүүлж буй төр, хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллага нь энэхүү зааврыг мөрдөж ажиллана.

2. Эрүүл мэндийн байгууллагууд нь товлосон хугацаанд мэдээ гаргах ажилтныг байгууллагын даргын тушаалаар томилон ажиллуулна.

3. Мэдээний тасралтгүй, шуурхай, үнэн зөв бодитой байдалд байгууллагын дарга, захирал нар байнгын хяналт тавьж, тулгамдсан асуудлыг (интернет, компьютер, мэдээ гаргах ажилтан) шуурхай шийдвэрлэнэ.

4. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагаас хүснэгтийн дагуу мэдээг авч ЭМЯ-ны Халдварт өвчний хэлтсийн eoc@moh.gov.mn хаягаар өдөр бүрийн 10.00 цагт илгээнэ.

5. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын 7 хоногийн эргэн мэдээлэл бэлтгэж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

6. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай үйлчлүүлэгчийг эмчилж буй эмнэлгийн ор болон хүний нөөцийн мэдээг 7 хоногийн Баасан гарагаар тасалбар болгож, тухайн өдрийн байдлаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын долоо хоногийн эргэн мэдээлэлд оруулж мэдээлнэ.

7. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/363 дугаар тушаалын коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөөцийн мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэж, Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын долоо хоногийн эргэн мэдээлэлд оруулж мэдээлнэ.

## ХҮСНЭГТ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАНДАЛТ, ХЯНАЛТЫН МЭДЭЭ

| № | Үзүүлэлт | Мэдээний задаргаа | Давтамж | Мэдээлэх байгууллага | Мэдээлэл нэгтгэх байгууллага | Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг | Мэдээллийн эх сурвалж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | **1. Батлагдсан тохиолдол** | | | | | |
| 1 | Батлагдсан тохиолдол | Нийт Үүнээс: | Өдөр бүр | КОВИД-19 халдварын шинжилгээний лаборатори | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | ПГУ | Өдөр бүр | КОВИД-19 халдварын шинжилгээний лаборатори | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Түргэвчилсэн тест | Өдөр бүр | Сум, өрхийн Эрүүл мэндийн төв | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Эмнэлзүй | Өдөр бүр | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Улаанбаатар | Өдөр бүр | Сум, өрхийн Эрүүл мэндийн төв | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Аймагт | Өдөр бүр | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Хүүхэд (0-17 насны) | Өдөр бүр | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Жирэмсэн эмэгтэй | Өдөр бүр | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| 2 | Халдварын эх уурхай | Гаднаас зөөвөрлөгдсөн | Өдөр бүр | ХӨСҮТ | ХӨСҮТ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Хавьтлаас | 7 хоногоор | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой | 7 хоногоор | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | 7 хоногийн мэдээгээр |
| | | Тодорхойгүй | 7 хоногоор | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | 7 хоногийн мэдээгээр |
| | | **2. Эмнэлзүйн мэдээлэл** | | | | | |
| 3 | Эмчлэгдэж байгаа | Эмнэлэгт (нийт) | Өдөр бүр | СЭМТ, Лавлагаа шатлалын болон хувийн хэвшлийн эмнэлэг | аймаг, нийслэлийн ЭМГ, Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв | ХӨСҮТ | Цахим систем |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Үүнээс: хүүхэд | Өдөр бүр | СЭМТ, Лавлагаа шатлалын болон хувийн хэвшлийн эмнэлэг | аймаг, нийслэлийн ЭМГ, Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Үүнээс: Жирэмсэн эмэгтэй | Өдөр бүр | СЭМТ, Лавлагаа шатлалын болон хувийн хэвшлийн эмнэлэг | аймаг, нийслэлийн ЭМГ, Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Гэртээ | Өдөр бүр | Өрх, сумын ЭМТ | аймаг, нийслэлийн ЭМГ | | Цахим систем |
| 4 | Эмчлүүлэгчийн эмнэлзүйн явц | Хөнгөн | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Хүндэвтэр | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Хүнд | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Нэн хүнд | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| 5 | Эмчлүүлэгчдээс | Эрчимт эмчилгээний тасгаас энгийн тасагт шилжсэн | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Энгийн тасгаас эрчимт эмчилгээний тасагт шилжсэн | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| 6 | Шилжилт хөдөлгөөн | Эдгэрч эмнэлгээс гарсан | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Гэрийн хяналтаас гарсан | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | аймаг, нийслэлийн ЭМГ | Цахим систем |
| | | | | **3. Хяналт** | | | |
| 7 | Хяналтад авсан хүний тоо | 24 цагийн дотор хяналтад авсан хүний тоо | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Ор хүлээгдэж байгаа хүний тоо | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| 8 | Хяналтад авсан хүнээс | Жирэмсэн эмэгтэйчүүд | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | 0-17 насны хүүхэд | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4. Дархлаажуулалтын дараах өвчлөл** | | | | | | | |
| 9 | Батлагдсан тохиолдлоос | 1-р тунд хамрагдсан | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | 2-р тунд хамрагдсан | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | Вакцин хийлгэснээс хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| 10 | Вакцины нэр | Синофарм | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | Спутник-В | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | Астра Зенека | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | Комернити | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| 11 | Эмчлүүлэгчийн эмнэлзүйн явц | Хөнгөн | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | Хүндэвтэр | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | Хүнд | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| | | Нэн хүнд | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | www.health.gov.mn |
| **5. Хавьтлын мэдээлэл** | | | | | | | |
| 12 | Хавьтлын тоо | Нийт Үүнээс: | Өдөр бүр | Лаборатори | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Гэрийн хяналтад байгаа | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Сүүлийн 24 цагт нэмэгдсэн хавьтлын тоо | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Хяналтад авч амжаагүй | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Хяналтаас гарсан хавьтлын тоо | Өдөр бүр | Тухайн байгууллага | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| **6. Лабораторийн мэдээлэл** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Шинжилсэн сорьцын тоо | Нийт сорьцын тоо Үүнээс: | Өдөр бүр | КОВИД-19 халдварын шинжилгээний лаборатори | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Ойрын хавьтлаас авсан сорьц | Өдөр бүр | КОВИД-19 халдварын шинжилгээний лаборатори | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Үүнээс эерэг сорьцын тоо | Өдөр бүр | КОВИД-19 халдварын шинжилгээний лаборатори | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |
| | | Шинжилгээ үргэлжилж байгаа | Өдөр бүр | КОВИД-19 халдварын шинжилгээний лаборатори | аймаг, нийслэлийн ЭМГ | ХӨСҮТ | Цахим систем |

--000--